

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч, Батсуурь Дуламсүрэн

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
1.1. Ерөнхий боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах богино хугацааны төлөвлөгөө, арга хэмжээ боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах							
1	Сургуульд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ, эрт илрүүлэг зохион байгуулна.	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан 6 настай хүүхдийн нас, эзлэх хувь	6 настай - 75.2 /2023/,	40	Сургуулийн насны хүүхдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг нь хүүхдийн амь нас, амьдралын чанар, суралцах чадварт хохирол учруулах өвчнийг эрт үед нь илрүүлэх, түүнийг үр дүнтэй эмчилж, ирээдүйд учирч болзошгүй хүндрэл, нас баралт, санхүүгийн дарамт, суралцахад саад болох нөхцөл байдлаас сэргийлэх зорилгоор “Сургуульд суурилсан эрт илрүүлгийн тогтолцоог сайжруулах бодлого”-ын хүрээнд нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр анги буюу 6 настны нүд, шүд, зүрхний эрт илрүүлгийн үзлэг 2024 оны 4 дүгээр улирлаас эхэлж, нийт 69,127 суралцагч буюу нийт 6 настангуудын 94,8 хувийг нь хамруулсан. Үүнээс зүрхний үзлэгт 55,482 суралцагч хамрагдсанаас 10,487 суралцагчийг	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					илрүүлж, дараагийн шатлалд 5,225 суралцагчийг, нүдний үзлэгт 50,160 суралцагч хамрагдсанаас 9,098 суралцагчийг илрүүлж, дараагийн шатлалд 1037 суралцагчийг, шүдний үзлэгт 59,308 суралцагч хамрагдсанаас 48,025 суралцагчийг илрүүлж, дараагийн шатлалд 24,474 суралцагчийг тус тус шилжүүлэн эмчлүүлсэн байна. Нүдний харааны үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн 4,290 нь холын хараа тэнцээгүй, 1,648 нь ойрын хараа тэнцээгүй, 2,770 нь стерео хараа тэнцээгүй байсан бол 5,797 хүүхэд нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай гэсэн үр дүн гарсан. Хавсралтаар линк орууллаа. https://eruulhuuhed.mn/mainDashboard/3 Хавсралт: 1 файл		
2	“Сургуулийн соёл, суралцагчийн төлөвшил” арга хэмжээг хэрэгжүүлэх удирдамжийн төсөл боловсруулах	Арга хэмжээний удирдамжийг эцэслэн боловсруулсан байна.	-	100	Боловсролын сайдын 2025 оны А/224 дүгээр тушаалаар “Сургуулийн соёл-суралцагчийн төлөвшлийг дэмжих үйл ажиллагааны удирдамж”-ийг батлуулж, ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүллээ. Энэхүү удирдамж нь сургуулийн эерэг соёл төлөвшүүлэхэд чиглэсэн бөгөөд энэ хүрээнд талуудын хамтын оролцоо, зөв хандлага, ёс зүй, харилцан хүндлэл, итгэлцэл, дэмжлэгт суурилан сургуулийн хамт олны үнэт зүйл, эерэг дадал, харилцаа, хандлагыг дэмжих, суралцагчийн төлөвшилд талуудын оролцоог нэмэгдүүлэх 4 чиглэлд хамаарах үйл ажиллагааг тус тус тодорхойлсон. Удирдамжийг төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулиуд өөрийн онцлогт нийцүүлэн 2025-2026 оны хичээлийн	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					жилээс 3 үе шаттай хэрэгжүүлнэ. Мөн удирдамжид заасан үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх тогтмол ажлын төлөвлөгөөний нэгэн хувилбарыг боловсруулсан. Хавсралт: 1 файл		
3	“Эрүүл аюулгүй сургууль” арга хэмжээ, төлөвлөгөөг Эрүүл мэнд, Боловсролын сайд хамтран баталж, хэрэгжүүлнэ.	“Эрүүл, аюулгүй сургууль” арга хэмжээг боловсруулж батлуулна.	-	10	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч эрүүл, аюулгүй, ээлтэй орчинд сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, эрүүл мэндийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж, эрүүл амьдрах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэн, тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дээшлүүлэх зорилгоор Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2025 оны А/53, А/37 дугаар хамтарсан тушаалаар “Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээ (2024-2028)-ний төлөвлөгөөг батлуулсан. Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээний төлөвлөгөөг (1) эрүүл, аюулгүй сургуулийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох; (2) суралцагч, багш, ажилтны эрүүл мэндийн боловсрол, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх; (3) сургуульд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим мэдээллийн сан бүрдүүлэх; (4) сургуульд эрүүл, аюулгүй, ээлтэй очин бүрдүүлэх; (5) сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээг бэхжүүлэх; (6) оролцогч талуудын тэгш оролцоо, түншлэл, үр дүнтэй хамтын ажиллагааг эхлүүлэх зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төлөвлөгөөг боловсрол, эрүүл мэндийн салбар болон орон нутгийн Засаг даргын	1-р сар, 6-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					тамгын газар хамтран хэрэгжүүлэх бөгөөд арга хэмжээний үр нөлөөг 17 шалгуур үзүүлэлтээр жил бүр дүгнэж байхаар тусгасан. Хавсралт: 1 файл		
4	Боловсролын яамны дэргэдэх “Хүүхдийн төлөө дэд зөвлөлийн ажиллах дүрэм”-ийг боловсруулж, батлуулах	Дүрмийн төсөл боловсруулалтын хувь, баталсан шийдвэр	-	100	Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн дүрэм”-ийн 3.6-д заасны дагуу Боловсролын яамны дэргэд боловсролын салбарын хүүхдийн эрхийг хангах, холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах дэд зөвлөлийг байгуулсан. Энэхүү Боловсролын яамны дэргэдэх “Хүүхдийн төлөө дэд зөвлөлийн ажиллах дүрэм”-ийг боловсруулан Боловсролын сайдын 2025 оны А/24 дүгээр тушаалаар батлууллаа. Дэд зөвлөлийн дүрэмд зөвлөлийн ажиллах зарчим, чиг үүргийг тодорхойлж, зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, тайлагнал, хяналтыг нарийвчлан зохицууллаа. Боловсролын яамны дэргэдэх хүүхдийн төлөө дэд зөвлөлийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг дэд зөвлөлийн дарга бөгөөд Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хавсралт: 2 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
5	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны	Төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна.	-	100	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.16-д хэрэгжүүлэх хүрээнд 2024 онд зохион байгуулсан ерөнхий боловсролын	4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

	орчин, үйлчилгээг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж батлуулах				сургуулийн дотуур байрны нөхцөл байдал, хүчин чадлыг тодорхойлох судалгаанд үндэслэн "Хүүхдэд ээлтэй дотуур байр" арга хэмжээний төлөвлөгөө /2025-2028/-г боловсруулж, Боловсролын сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/254 дүгээр тушаалаар батлууллаа. Төлөвлөгөөний төслийг нийслэлийн боловсролын газар, Боловсролын ерөнхий газрын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, НҮБ-ын Хүүхдийн сан, Хүн амын сангийн мэргэжилтнүүдээр хэлэлцүүлэн, санал авч, эцэслэсэн. Төлөвлөгөөнд (1) дотуур байрны менежментийг сайжруулах, (2) хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, (3) орчин, нөхцөл, дэд бүтцийг сайжруулах, (4) хамтын ажиллагаа, түншлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр 37 арга хэмжээг төлөвлөөд байна. Суралцагч, багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамтын оролцоонд суурилан хүүхдэд ээлтэй дотуур байрны үйлчилгээг нэвтрүүлж, дотуур байранд амьдарч буй хүүхдийн хөгжил, хамгаалалд ахиц гаргана. Хавсралт: 1 файл		даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
6	Сургуульд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ, эрт илрүүлгийг удирдлага, зохион байгуулалтаар	Сургуульд суурилсан эрүүл мэндийн үйлчилгээ, эрт илрүүлгийг удирдлага зохион байгуулалтаар хангана.	-	50	Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдын нүдний эмгэгийн эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулахад шаардлагатай харааны хэрэглэгдэхүүнийг худалдан авахад шаардагдах зардал 300,000,000 сая төгрөгийг Боловсролын сайдын 2025 оны А/107 дугаар тушаалаар батлан, эрт	4-р сар, 5-р сар, 6-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн

хангах				илрүүлэг зохион байгуулах боломж, нөхцөлийг бүрдүүлж, нийт 69,127 суралцагч буюу нийт 6 настангуудын 94,8 хувийг эрт илрүүлэгт хамрууллаа. Түүнчлэн "Хараа шалгах аргачлал"-ын дагуу 5 удаагийн сургалтад нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 300 эмч, орон нутгийн боловсролын болон эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд, нүдний эмч нарын төлөөлөл 92 оролцогчийг сургагч багшаар бэлтгэхэд удирдлага зохион байгуулалтаар хангаж, Эрүүл мэндийн яам, Орбис олон улсын байгууллагатай хамтран ажиллалаа. Эрт илрүүлэгт хамрагдсан суралцагчдаас зүрхний үзлэгт 55,482 суралцагч хамрагдсаны 10,487 суралцагчийг илрүүлж, дараагийн шатлалд 5,225 суралцагчийг, нүдний үзлэгт 50,160 суралцагч хамрагдсанаас 9,098 суралцагчийг илрүүлж, дараагийн шатлалд 1037 суралцагчийг, шүдний үзлэгт 59,308 суралцагч хамрагдсанаас 48,025 суралцагчийг илрүүлж, дараагийн шатлалд 24,474 суралцагчийг тус тус шилжүүлэн эмчлүүлсэн байна. Нүдний харааны үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн 4,290 нь холын хараа тэнцээгүй, 1,648 нь ойрын хараа тэнцээгүй, 2,770 нь стерео хараа тэнцээгүй байсан бол 5,797 хүүхэд нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай гэсэн үр дүн гарсан. Хавсралт: 2 файл	даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
1.2. Ерөнхий боловсролын салбарын нийтлэг харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг бодлогын удирдлага, зохицуулалтаар хангах					

7	"Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам"-ын төслийг боловсруулж, батлуулна.	Сайдын тушаал	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/453 тушаал	Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын төслийг боловсруулах	Боловсролын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын төслийг маягтуудын хамт эцэслэн боловсруулж, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны төлөөлөл (2025.04.23) болон Боловсролын ерөнхий газар, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг, нийслэлийн боловсролын газрын мэргэжилтнүүд (2025.05.09), олон улсын байгууллагын төлөөлөл (2025.05.12)-өөр тус тус 3 удаа хэлэлцүүлж, санал аваад байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын төсөл нь хүүхэд хамгааллын үйлчилгээ, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үйлчилгээний бүтэц, зохион байгуулалт, хяналт, үнэлгээ гэсэн агуулгыг хамарсан. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд шуурхай тусламжийн, хамгаалах нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйлчилгээг хамруулахаар тусгасан бөгөөд үйлчилгээ тус бүрт хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнийг хариуцах гүйцэтгэх албан хаагчийг нарийвчлан зохицуулсан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.5.1-д "Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам" гэж заасан байх тул сургуулийн өмнөх болон мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын асуудал хариуцсан нэгжээс журмын хавсралтаа ирүүлэхээр батлуулахаар ажиллаж байна. Хавсралт: 1 файл	3-р сар, 6-р сар, 9-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
8	Сургуулийн нийгмийн	Шалгуур үзүүлэлттийн	2013 оны Засгийн	30	Сургуулийн нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгоход тавигдах	3-р сар, 6-р сар,	Өөрийн

	ажилтанд мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулна.	төсөл боловсруулалтын хувь	газрын 113 тогтоол		шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулж, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны төлөөлөл (2025.03.14) болон нийгмийн ажилтан бэлтгэдэг их, дээд сургуулийн мэргэжлийн тэнхимийн багш нар (2025.04.28, 2025.05.27)-аар тус тус 3 удаа хэлэлцүүлж, санал аваад байна. Шалгуур үзүүлэлтийн төсөл нь хүүхэд хамгааллын ажил, хүүхэд хамгааллын хөтөлбөр, үйлчилгээний загвар, судалгаа, шинжилгээ, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг, хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоо, мэргэжлийн хөгжил гэсэн агуулгыг хамарсан. Мэргэшлийн ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг тус бүрд 10 шалгуур үзүүлэлт байхаар тусгасан. Шалгуур үзүүлэлт бүр нь тодорхой, хэмжихүйц байдлыг хангаж, нотлох баримтаар баталгаажих боломжтой байх, шатлал ахих тусам шаардлагатай мэдлэг, ур чадвар, арга зүйн манлайлал гүнзгийрч байгаа шаталсан бүтэцтэй байхаар томьёолсон. Харин Засгийн газрын 2013 оны 229 дүгээр тогтоолоор баталсан “Сургуулийн нийгмийн ажилтанд мэргэшлийн зэрэг, нэмэгдэл хөлс олгох журам”-ыг холбогдох хуульд нийцүүлэн хүчингүй болгох тухай Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулгын хамт бэлтгээд байна. Хавсралт: 2 файл	9-р сар, 11-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
9	Боловсролын салбар дахь	Нийтлэг шаардлагын	-	100	Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд	1-р сар, 2-р сар,	Өөрийн

	хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлагын төсөл боловсруулна.	төсөл боловсруулалтын хувь			“Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага”-ын төслийг боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн ерөнхий газар, Боловсролын ерөнхий газар, нийслэлийн боловсролын газрын холбогдох нэгжийн дарга, мэргэжилтний төлөөлөл (2025.04.11), түүнчлэн нийслэлийн сургуулийн нийгмийн ажилтны төлөөлөл (2025.05.09)-өөр тус тус хэлэлцүүлж, санал авч, эцэслэсэн. Нийтлэг шаардлагын төсөлд боловсролын орчинд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүний нөөц, сургалтын байгууллагын орчин, санхүүжилт, хянал-шинжилгээ, үнэлгээнд тавих шаардлагыг тус тус тогтоосон бөгөөд боловсролын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхдээ “Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 6949:2021” стандартыг мөрдлөг болгож, өмчийн хэлбэрээс үл хамаарч уг шаардлагыг дагаж мөрдөхөөр заасан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.9-д уг нийтлэг шаардлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заасан тул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (2025.05.09-ний өдрийн 1/1974 тоот), хамтран батлахаар албан бичиг хүргүүлээд байна. Тус байгууллагуудаас батлан ирүүлэхийг хүлээж байна. Хавсралт: 2 файл	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	----------------------------	--	--	---	--

10	Суралцагчийн эрүүл мэндийн картын загвар, заавар боловсруулах, турших, хэлэлцүүлэх	Картын загвар, зааврын төсөл	-	Суралцагчийн эрүүл мэндийн картын загвар, зааврын төсөл боловсруулах	Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/53, А/37 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эрүүл, аюулгүй сургууль” арга хэмжээний хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн эрүүл мэндийн картын төслийн агуулгыг боловсрууллаа. Суралцагчийн эрүүл мэндийн картын төсөлд санал авах хэлэлцүүлгийг Эрүүл мэндийн яам, эрүүл мэндийн төв, НҮБ-ын Хүн амын сан, Хүүхдийн Сан болон ерөнхий боловсролын сургуулийн эмч нарын төлөөллийг оролцоотой зохион байгууллаа /202504.30/. Эрүүл мэндийн картын агуулгад суралцагчийн мэдээлэл, дархлаажуулалтын түүх, эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн үзлэг (бие бялдар, хоол тэжээлийн үнэлгээ, нүд, чих, хамар, хоолой, эрхтэн тогтолцооны үзлэг, сэтгэцийн эрүүл мэнд, шүд, амны хөндийн эрүүл мэнд), зөвлөмж-мэдээллийг багтаасан. Энэхүү картын төслийг ерөнхий боловсролын 3 сургууль дээр туршиж үзэхээр ажиллаж байна. Одоогоор ерөнхий боловсролын Монгол-Оросын хамтарсан 3 дугаар сургууль, ерөнхий боловсролын 84 дүгээр сургууль эрүүл мэндийн картын төслийг турших туршилтад хамрагдахаар хүсэлтээ ирүүлээд байна. Хавсралт: 1 файл	4-р сар, 6-р сар, 8-р сар, 10-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
11	Харъяа байгууллагын албан хаагчдыг чиг үүргээ хэрэгжүүлэхэд	Дэмжлэг үзүүлсэн байгууллага, албан хаагчийн тоо	-	Суралцагчийн эрх, хамгааллын асуудал хариуцсан	Харъяа байгууллагын албан хаагчдыг чиг үүргээ хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө чиглэлээр хангах, хамтран ажиллах хүрээнд дараах ажлуудыг зохион байшуулж,	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө чиглэлээр хангах, хамтран ажиллах			мэргэжилтэн, албан хаагчдад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтарч ажилласан байна.	ажиллалаа. Сургуулийн сурч, хөгжих үйл явцыг хүүхдийн эрхэд суурилсан хандлагаар дэмжих арга зүйд суралцах, сургуулийн багш ажилтнууд, эцэг эхчүүдийг сургах арга барил эзэмшүүлэх зорилгоор Японы Хүүхдийг ивээх сантай хамтран "Хамгааллын алхмууд: Кейс менежментийн нийтлэг арга зүй" 16 цагийн сургалтыг 2025 оны 2 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулав. Сургалтад Боловсролын ерөнхий газар, НБГ, БЗД, БГД, ХУД, ЧД, СБД-ийн боловсролын хэлтэс, оролцож, хүүхэд хамгааллын кейс менежментийн нийтлэг арга зүй шинэчилсэн арга зүйн багцад суралцан, хүүхэд гэр бүлд кейс менежментийн үйлчилгээ үзүүлэх мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлсэн. Түүнчлэн Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/53, А/37 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Эрүүл-аюулгүй сургууль”, “Хүүхдэд ээлтэй дотуур байр” арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын оролцоог хангах, нэгдсэн ойлголтод хүрэх, хамтран ажиллах боломжийг тодорхойлох зорилгоор Боловсролын ерөнхий газар, Нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн холбогдох газар, нэгжийн мэргэжилтнүүдийг мэдээллээр хангах, сургалтыг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдөр зохион байгууллаа. Сургалтын үр дүнд батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөний үр дүн, тайланг нэгдсэн ойлголт, загвараар гаргах боломж бүрдсэн.		үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	--	--	--	--	--	---

					Хавсралт: 3 файл		
1.3. Ерөнхий боловсролын салбарын урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах							
12	Ерөнхий боловсролын салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн ил тод байдал	2024 оны гүйцэтгэлийн түвшингээр	Ерөнхий боловсролын салбарт хамаарах эрх зүйн акт, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хуульд заасны дагуу эрх ашиг хөндөгдөх талууд, олон нийтэд хүргэсэн байна.	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор боловсруулж буй “Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам” болон “Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага”-ын төсөлд олон нийтийн санал авахаар 2025 оны 04 дүгээр сард яамны вэб сайтад https://moe.gov.mn/post/165283 https://moe.gov.mn/post/154822 тус тус байршуулж, санал авсан. Боловсролын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/53, А/37 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Эрүүл, аюулгүй сургууль арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө /2025-2028/" https://moe.gov.mn/post/166621 , Боловсролын сайдын 2025 оны А/224 дүгээр тушаалаар батлагдсан "Сургуулийн соёл-суралцагчийн төлөвшлийг дэмжих үйл ажиллагааны удирдамж"-ийг https://moe.gov.mn/post/166620 тус тус нээлттэй байршуулж, мэдээлэл хүргэж ажиллалаа.	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Өөрийн албаны тухай болон хариуцсан ажлын чиглэлээр хууль тогтоомж, эрх зүйн мэдлэгтэй байж, мэдлэг, чадвараа тасралтгүй дээшлүүлэх	Шинээр батлагдсан төрийн албаны тухай болон хариуцсан ажлын чиглэлээр бодлого, хууль тогтоомж, эрх зүйн актуудыг судлах, мэдээллийн сан үүсгэж, ажил хэрэгтээ ашигласан байна.	-	Шинээр батлагдсан төрийн албаны тухай болон хариуцсан ажлын чиглэлээр бодлого, хууль тогтоомж, эрх зүйн актуудыг судлах, мэдээллийн сан үүсгэж, ажил хэрэгтээ ашигласан байна.	Монгол Улсын Их хурлын 2024 оны нэгдсэн чуулганаар батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хууль 2024 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан тус хууль болон дагалдан гарсан хууль, эрх зүйн баримт бичгийг судалж, холбогдох стандарт, журам, нийтлэг шаардлагыг шинэчлэн боловсруулж байна./Боловсролын орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам, Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний нийтлэг шаардлага/. Түүнчлэн Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 2025 онд батлагдсан “Хүүхдэд сэтгэлзүйн тусламж үйлчилгээ үзүүлэх нийтлэг шаардлага: MNS7065:2025, Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлэх хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний стандарт MNS7066:2025 стандартуудыг судалж, мэдлэг ур чадвараа ахиулж, ажилдаа тусган ажиллаж	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					байна. Түүнчлэн батлагдсан хууль, тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан эрх зүйн баримт бичгүүдийг нэгтгэн мэдээллийн сан үүсгэж, ажил хэрэгтээ ашиглаж байна.		
2	Эрхэлсэн ажлын хүрээнд мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдана.	Эрхэлсэн ажлын хүрээнд мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдана.	-	Сертификат авсан байна.	Төрийн албаны зөвлөл болон тус яамнаас албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулсан “Мэдээллийн цаг” арга хэмжээнд тухай бүр оролцож, мэдлэг ур чадвараа дээшлүүлж, үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. Үүнд: Төрийн албан дахь ёс зүйн боловсрол, Хувь хүн ба байгууллагын кибер аюулгүй байдал, кибер гэмт хэргийн хуулийн хариуцлага, Ажлын байрны ёс зүй, хөрөнгө оруулалт ба хөрөнгийн зах зээлийн тухай, Батлан хамгаалах хууль тогтоомж, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль болон Дайчилгааны тухай хууль сургалтуудад хамрагдлаа. Түүнчлэн Японы Хүүхдийг ивээх сангаас зохион байгуулсан "Хамгааллын алхмууд: Кейс менежментийн нийтлэг арга зүй" 16 цагийн сургалтад 2025 оны 2 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд хамрагдаж мэдлэг, ур чадвараа ахиулж сертификат гардан авлаа. Түүнчлэн Бүгд Найрамдах Солонгос Улсын Дэжон хотод 2025 оны 6 дугаар сарын 10-18-ны өдрүүдэд зохион байгуулагдах цахим боловсролын сургалтад	6-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

					хамрагдана.	Хавсралт: 1 файл	
--	--	--	--	--	-------------	------------------	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгааллын бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч, Батсуурь Дуламсүрэн

/...../

Огноо: